



**НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

┌ Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны  
үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 “д”, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Хөгжилд хөтлөх Сүхбаатар дүүрэг” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дүүргийн Засаг дарга /Х.Болормаа/-д даалгасугай.

- 2.1. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт батлах
- 2.2. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн дүүргийн төсөвт тусган хэрэгжүүлэх
- 2.3. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2020-2024 онд үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудын биелэлтийг гаргаж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах
- 2.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, биелэлтийг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах

3. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, чиглэл өгч ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА  Б.ЭНХБОЛД



1140100035

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн  
иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2020 оны 10 дугаар сарын 14-ны  
өдрийн 08 дугаар тогтоол

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ  
“ХӨГЖИЛД ХӨТЛӨХ СҮХБААТАР ДҮҮРЭГ” ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

НЭГ. “COVID-19” ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ  
ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН  
ТУУЛАХ БОДЛОГО

- 1.1 Иргэд олон нийтийг “Ковид-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, нөөцийн бэлэн байдлыг хангана.
  - 1.1.1 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, сургууль, цэцэрлэг, аж ахуйн нэгж байгууллагуудын орчинд ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл, сурталчилгаа хийж ажиллана.
  - 1.1.2 Цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг иргэдэд хүргэж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана.
  - 1.1.3 Халдварт өвчний тандалт сэргийлэлт, бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулан өвчний тархалтыг бууруулахад дэмжлэг үзүүлнэ.

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО  
/ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ/

ЭРҮҮЛ МЭНД

- 2.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлж, “ИРГЭН ТӨВТ” үйлчилгээг нэвтрүүлнэ.
  - 2.1.1 Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлгийг дүүргийн төсвөөр шинээр барьж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
  - 2.1.2 Дүүргийн Эрүүл мэндийн төвийг эрүүл мэндийн салбарт шинээр нэвтэрсэн оношилгоо, шинжилгээ, эмчилгээний техник технологи, шаардлагатай тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар хангана.
  - 2.1.3 Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй 3 талт гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавин үр дүнг тооцож, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэн хамтран ажиллана.
  - 2.1.4 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, чанар хүртээмжийг дээшлүүлж, нэн шаардлагатай мэргэшлээр эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургалтад хамруулж, чадавхжуулна.
  - 2.1.5 Эрүүл мэндийн төвийг түшиглэн “Нийгмийн эрүүл мэндийн төв”-ийг үе шаттай байгуулж, үйл ажиллагааг дэмжин ажиллана.
  - 2.1.6 Иргэн бүрийг нас, хүйсийн бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулж, “ИРГЭН ТӨВТ” эрүүл мэндийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгоно.
- 2.2 Иргэн бүрд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ.

- 2.2.1 Иргэдийг зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт жилд 1 удаа хамруулан эрүүлжүүлнэ.
- 2.2.2 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн амны хөндийн эрүүл мэндийг хамгаалах, амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 2.2.3 Сүрьеэ өвчний эрт илрүүлгийг явуулын хэлбэрт шилжүүлж, эмчилгээний үр дүнг нэмэгдүүлнэ.
- 2.2.4 Сургуулийн ахлах ангийн сурагчид, 18-аас дээш насны залуучуудыг БЗДХ, ХДХВ, 45-аас дээш насны иргэдийг Хепатитийн В, С вирус зэрэг халдварт өвчний эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулж, “ЭРҮҮЛ ГЭР БҮЛ-ЭРҮҮЛ ХҮҮХЭД” хөдөлгөөн өрнүүлнэ.
- 2.2.5 Дархлаажуулалтын хамрагдалтыг сайжруулж, халдварт өвчний тохиолдлыг бууруулна.
- 2.2.6 Ажил эрхэлдэггүй, дунджаас доогуур орлоготой иргэдэд эрүүл мэндийн даатгалд хамрагдах талаар сурталчилж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, “Хэнийг ч орхигдуулахгүй байх” арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.2.7 Сүхбаатар сувиллын газрыг “Харвалтын дараах сэргээн засах төв” болгон өргөжүүлж, эмчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.2.8 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагааг дэмжин ажиллана.

#### БИЕИЙН ТАМИР

- 2.3 Иргэдийг нийтийн биеийн тамир спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангана.
  - 2.3.1 Нийтийн биеийн тамир, спортын тэмцээн уралдааныг тогтмолжуулж, иргэдийн бие бялдрын хөгжлийг дэмжиж ажиллана.
  - 2.3.2 Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг өргөжүүлэн дэмжиж ажиллана.
  - 2.3.3 Иргэд, зорилтот бүлгүүдийн дунд бүх ард түмний, хүүхдийн, үндэсний, оюутны спортын их наадмуудыг зохион байгуулж, дүүргийн баг тамирчдыг оролцуулна.
  - 2.3.4 Иргэдэд амьдралын зөв дадал хэвшил олгох, “Зохистой хооллолт-идэвхтэй хөдөлгөөн” аян, бие бялдрын чийрэгжилтийн төвшин тогтоох сорил хөтөлбөрийг өрнүүлнэ.
  - 2.3.5 “Спорт цогцолбор”-ын барилгын ажлын явцыг эрчимжүүлж, ашиглалтад оруулна.

#### БОЛОВСРОЛ

- 2.4 Сургалтын чанарыг сайжруулж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
  - 2.4.1 Төрийн өмчийн сургууль, цэцэрлэгийн барилгыг өргөтгөх, шинээр барих ажлыг улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлнэ.
  - 2.4.2 Цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх замаар сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын бохир жинг 89.0 хувьд хүргэнэ.
  - 2.4.3 Багш, удирдах ажилтны мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна.
  - 2.4.4 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлж, сурлагын чанарт хяналт тавина.

- 2.4.5 “Насан туршийн боловсролын төв”-өөр олгох сургалтын чанар, хүртээмжийг сайжруулж, сургуульд суралцаагүй, сургууль завсардсан, зорилтот бүлгийн хүүхэд, залуучууд, иргэдэд бага, суурь, бүрэн дунд боловсролыг эзэмшүүлэх, иргэдийн нийгмийн боловсролыг дээшлүүлэх цахим платформд суурилсан сургалтын үйл ажиллагааг дэмжиж, шаардлагатай сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана.
- 2.5 Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, хүүхэд, эцэг эх, багшийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 2.5.1 Дүүргийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн засвар, тохижилт, хөрөнгө оруулалтын ажлыг эрэмбэлэх цахим мэдээллийн сан бүрдүүлж, сургалтын орчныг сайжруулна.
- 2.5.2 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бүсэд аюулгүй байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ, автобусны үйлчилгээ, туршлагыг нэвтрүүлэн “ГЭРТЭЭ ХАРИХ ГЭРЭЛТЭЙ ЗАМ” арга хэмжээг хэрэгжүүлж, хүүхдийн аюулгүй орчин бүрдүүлнэ.
- 2.5.3 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчинд аюулгүй байдлыг хангасан, стандартын шаардлагад нийцсэн хогийн сав, гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлж, хүүхдийг зам тээврийн осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлнэ.
- 2.5.4 Хүүхэд, залуучуудын номын сангийн хүртээмжийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг сайжруулна.
- 2.5.5 “Мэргэжил сонголтын зөвлөх үйлчилгээний төв” байгуулж, сурагчдыг ажил, мэргэжлээ зөв сонгоход зөвлөн туслах үйлчилгээг шинээр нэвтрүүлнэ.
- 2.5.6 Ерөнхий боловсролын сургуульд “Сэтгэл зүйн танхим”-ыг нээж, үйл ажиллагааг эхлүүлнэ.
- 2.5.7 Багшийн ажлын байран дээрээ хөгжих боломжийг бүрдүүлэх, сурлагын амжилт, чанарыг ахиулах зорилгоор хүүхэд, эцэг эх, багшийн цахим хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.
- 2.5.8 Сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулж, үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- 2.5.9 Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах талаарх мэдлэгийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд сурталчлан таниулах ажлыг эхлүүлж, хэрэгжүүлнэ.
- 2.5.10 Эко сургууль, ногоон цэцэрлэг бий болгох аяныг өрнүүлнэ.

#### НИЙГМИЙН ХАЛАМЖ

- 2.6 Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, тусламж үйлчилгээг сайжруулна.
- 2.6.1 Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулан иргэдэд түргэн шуурхай хүргэнэ.
- 2.6.2 Ажил эрхэлдэггүй, нийгмийн халамжид хамрагддаггүй зорилтот бүлгийн иргэдэд амьжиргааны бодит туслалцаа үзүүлнэ.
- 2.6.3 Хүмүүнлэгийн чиглэлээр Засгийн газрын зарим чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.6.4 Хөгжлийн бэрхшээлтэй хүний салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.

#### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- 2.7 Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дэмжин ажиллана.
- 2.7.1 Орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэгч татвар төлөгч, ажил олгогчдын чуулга уулзалтыг жил бүр зохион байгуулна.

- 2.7.2 Ажилгүй, орлогогүй иргэдийг мэргэжлийн болон давтан сургалтаар мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэн чадавхжуулж, хөдөлмөр эрхлэхэд нь зуучилж ажиллана.
- 2.7.3 Өрх толгойлсон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байр бий болгох, өрхийн үйлдвэрлэл, бизнесээ хөгжүүлэхэд нь дэмжин ажиллана.
- 2.7.4 Бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын цагийн уян хатан зохицуулалт хийж, оюутан, залуучуудыг цагаар болон өдрөөр ажиллах боломж нөхцөлийг бүрдүүлсэн аж ахуйн нэгж байгууллагыг дэмжин ажиллана.
- 2.8 Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.
  - 2.8.1 Дүүргийн жижиг, дунд үйлдвэр эрхлэгч болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг технологийн шийдлээр дэмжихэд анхаарч, бүтээгдэхүүнийг сурталчилна.
  - 2.8.2 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний дагуу хувиараа хөдөлмөр эрхлэгч, жижиг, дунд бизнес эрхлэгчид, Старт апп бизнес компаниуд, инновацийн төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудыг хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэгт хамруулна.
  - 2.8.3 Зорилтот бүлгийн болон үйлдвэрлэл эрхлэгчдийг ажлын байрны хөнгөлөлттэй түрээсийн үйлчилгээ, бизнес инкубацийн арга хэмжээнд хамруулна.
  - 2.8.4 Дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн дэргэдэх мэдээллийн төвд үйлдвэр эрхлэгчдийн хэрэгцээнд тулгуурлан төрөл бүрийн сургалт, уулзалтыг зохион байгуулна.
  - 2.8.5 Тогтвортой үйл ажиллагаа эрхэлж, байнгын ажлын байр шинээр бий болгосон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, хамтран ажиллах, гадаад, дотоодын зах зээлд таниулах, үзэсгэлэн худалдаанд хамруулна.

#### СОЁЛ УРЛАГ

- 2.9 Соёлын үйл ажиллагааг дэмжиж, түгээн дэлгэрүүлнэ.
  - 2.9.1 Төрөөс соёлын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж, хүүхэд, залуучууд, иргэдийн авьяасыг нээн хөгжүүлэх, урлаг соёлын олон талт үйл ажиллагааг зохион байгуулна.
  - 2.9.2 Залуучуудыг хотын соёлд суралцуулах, сөрөг зан үйл хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулна.
  - 2.9.3 Хөшөө, дурсгалт газруудын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, соёлын аялал жуучлалыг дэмжинэ.
  - 2.9.4 Хотын соёлыг төлөвшүүлэх, түгээн дэлгэрүүлэх, амьдралын зөв дадал, сайн зан чанар, эх оронч үзлийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

#### ГЭР БҮЛ

- 2.10 Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжин гэр бүлийн тогтвортой байдлыг ханган ажиллана.
  - 2.10.1 Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг дэмжин ажиллана.
  - 2.10.2 Хүүхэд, гэр бүлд ээлтэй орчин бүрдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагааг сайжруулна.
  - 2.10.3 Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, бүх төрлийн цахим мэдээллийн халдлагаас урьдчилан сэргийлэх ажлыг өрнүүлнэ.

- 2.10.4 Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хороодын “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагааг сайжруулж, нэмэгдэл урамшуулал олгоно.
- 2.11 Ахмад настны хөгжил, хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлнэ.
  - 2.11.1 Ахмад настан, зорилтот бүлгийн иргэдийн мэдээллийн санг бий болгож, чадамжийг дэмжих, нийгмийн амьдралд татан оролцуулах ажлыг зохион байгуулна.
  - 2.11.2 Ахмад настны эрүүл мэнд, өрхийн хөгжлийг дэмжин хөтөлбөр, арга хэмжээнд хамруулна.
  - 2.11.3 Дүүргийн иргэд, ахмад настуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх соёл урлагийг дэмжих, “Ахмадын настны хөгжил хамгааллын төв”-ийг барьж байгуулна.

**ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО  
/ӨСӨЛТИЙГ ӨРХ БҮРД СҮХБААТАР ДҮҮРЭГ/**

- 3.1 Дүүргийн төсвийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөж, ил тод мэдээлнэ.
  - 3.1.1 Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв санхүү, төрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг иргэдэд нээлттэй, ил тод тайлагнана.
  - 3.1.2 Дүүргийн төсвийн сахилга бат, хэмнэлт, санхүү тайлан бүртгэлийн стандарт, ил тод байдлыг хангах, дүүргийн санхүүгийн ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, идэвхжүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулна.
  - 3.1.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааг цахим системээр зохион байгуулж, мэдээллийг цаг тухайд нь олон нийтэд ил тод мэдээлнэ.
  - 3.1.4 Төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт түүний үр ашигтай байдалд хяналт тавьж, үйл ажиллагааг сайжруулж, төрийн үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил тод мэдээлнэ.
  - 3.1.5 Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ажлын саналыг иргэдээс нээлттэй болон цахимаар авч, иргэдийн бүлэг, олон нийтийн оролцоотойгоор гүйцэтгэж, нээлттэй ил тод болгоно.
  - 3.1.6 Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тухайн оны дүүргийн төсвийн төслийг олон нийтэд танилцуулах зорилгоор нийтийн сонсголыг зохион байгуулна.

**ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО  
/НЭЭЛТТЭЙ, ХАРИУЦЛАГАТАЙ СҮХБААТАР ДҮҮРЭГ/**

- 4.1 Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, ил тод хүргэнэ.
  - 4.1.1 Иргэдэд төрийн үйлчилгээг хөдөлгөөнт оффисоор үргэлжлүүлэн үзүүлнэ.
  - 4.1.2 Дүүрэг, хороодын иргэний танхимын үйл ажиллагааг идэвхжүүлэх, төр засгийн тогтоол шийдвэрийг тогтмол мэдээлж, иргэн төвтэй болгоно.
  - 4.1.3 Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор дүүргийн дэргэдэх хэлтэс, албад, хороодын иргэний танхимыг шаардлагатай хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана.

- 4.1.4 Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг жилд 2-оос доошгүй удаа олон нийтэд нээлттэй тайлагнана.
- 4.1.5 Төрийн зарим чиг үүргийг хороодод шилжүүлж, төрийн үйлчилгээг иргэнд ойртуулна.
- 4.1.6 Төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор урамшууллын тогтолцоог сайжруулна.
- 4.1.7 Шүүхийн шийдвэрийг биелүүлж, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 4.1.8 “Төрийн албан хаагчдыг сургах, мэргэшүүлэх, хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах хөтөлбөр” боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.1.9 Төрийн үйлчилгээнд иргэдээс шаарддаг бичиг баримтыг цөөрүүлж, төрд байгаа мэдээллийн санд үндэслэн иргэндээ үйлчилнэ.
- 4.1.10 Төрийн үйлчилгээг иргэдэд нэг цэгээр үзүүлэх хороо, ӨЭМТ, цагдаагийн хэсгийн цогцолбор байрыг шинээр барина.
- 4.2 Архив, албан хэрэг хөтлөлт, мэдээллийн аюулгүй байдлыг хангана.
  - 4.2.1 Иргэдийн өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх явцыг цахим бүртгэлд оруулж, цаг алдалгүй судлан үзэж, түргэн шуурхай шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж ажиллана.
  - 4.2.2 Төрийн архивын тусгай төрлийн баримтыг нэмэгдүүлэн цаасан баримтыг цахимжуулж, архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулна.
  - 4.2.3 Дүүргийн хөмрөг үүсгэгч байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын хариуцлага бүтээмжийг нэмэгдүүлж, чадавхжуулна.
  - 4.2.4 Мэдээллийн аюулгүй байдал, дотоод сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 4.3 Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
  - 4.3.1 Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлах, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулж, ил тод байдлыг хангаж ажиллана.
  - 4.3.2 Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэх тогтолцоог сайжруулна.
  - 4.3.3 Нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд холбогдох хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулж, нэгтгэн тайлагнана.
  - 4.3.4 Татварын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татвар хураалтыг нэмэгдүүлнэ.
  - 4.3.5 Ажил олгогч, даатгуулагчдад чиглэсэн сургалт зохион байгуулна.
  - 4.3.6 Дүүргийн иргэдэд батлан хамгаалах төрийн үйлчилгээг хүргэнэ.
  - 4.3.7 Монгол Улсын Статистикийн тухай хуулийн дагуу жил тутам, 5, 10 жилийн давтамжтай тооллогыг дүүргийн нутаг дэвсгэрт чанартай зохион байгуулна.
  - 4.3.8 Статистикийн албан ёсны болон анхан шатны нэгж хороодод бүртгэгддэг “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-гийн баяжилт, бүртгэлийг сайжруулснаар, төрийн мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.
  - 4.3.9 Албан ёсны Статистикийн мэдээ, тайланг бүрэн цахимжуулах чиглэлээр дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Аж ахуйн нэгж, байгууллага болон дүүргийн харьяа хэлтэс, хороодын ажлын албадын ажилтан, албан хаагчид статистикийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулж, мэргэшүүлэх, чадваржуулна.

- 4.3.10 Улсын бүртгэлийг чанаржуулж, улсын бүртгэгч нарын төрийн үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай тоног, төхөөрөмж, хэрэгслээр хангаж ажиллана.
- 4.3.11 Улсын бүртгэгч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх, албан хаагчийн ёс зүйн сургалтыг үе шаттай зохион байгуулж, иргэдэд хууль эрх зүйн сургалтыг бүсчлэн зохион байгуулна.
- 4.3.12 Сургалтын байгууллагуудад хяналт шалгалт хийнэ.
- 4.4 Дүүргийн гадаад харилцааг өргөжүүлнэ.
  - 4.4.1 Гадаад харилцааг өргөжүүлэн уламжлалт харилцаатай улс орны хот, дүүрэгтэй хамтран ажиллах хамтын ажиллагааг бэхжүүлж, шинээр улс орны хот, дүүргүүдтэй харилцаа тогтооно.
  - 4.4.2 Харилцаат хот, дүүргүүд рүү албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх сургалт, семинарт хамруулна.
  - 4.4.3 Гадаад, дотоод хамтын ажиллагаатай хот, дүүргүүдтэй эмч, сувилагч, багш, сурагч солилцооны хөтөлбөрийг нэмэгдүүлнэ.
  - 4.4.4 Дүүрэгт гадаадын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжиж, хамтран ажиллана.
- 4.5 Иргэдийн аюулгүй байдлыг хангаж, хэв журмыг сахиулна.
  - 4.5.1 Байгалийн гамшиг, гал түймэр, гэнэтийн гамшиг ослоос хамгаалах чиглэлээр иргэд, аж ахуй нэгж байгууллага, оюутан, сурагчдыг татан оролцуулж, анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгуулна.
  - 4.5.2 Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, “Олон нийтийн цагдаа”, “Оюутан цагдаа” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
  - 4.5.3 Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртөхөөс хамгаалах “Хүүхэд хамгаалагч” төслийг хэрэгжүүлж, хүүхдийг гэмт хэрэгт өртөх, хохирогч болох эрсдэлийг бууруулна.
  - 4.5.4 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нэгдсэн болон тусгай арга хэмжээг тогтмол зохион байгуулна.
  - 4.5.5 Хавар, намрын хуурайшилтын үед ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр урамшуулалт морин эргүүл ажиллуулна.
  - 4.5.6 Дүүргийн нутаг дэвсгэрт бүртгэгдсэн осол, хэргийн судалгааг үндэслэж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулна.
  - 4.5.7 Алба хаагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор шаардлагатай техник тусгай хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулна.
  - 4.5.8 Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулж, зохиомол түгжрэл саатлыг арилгах, техник, замын хяналтын ажил, арга хэмжээг зохион байгуулна.
  - 4.5.9 Сууц өмчлөгчдийн холбоодын хариуцлагыг өндөржүүлж, үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 4.6 Хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллана.
  - 4.6.1 Аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний байгууллагуудын соёл, чанарыг сайжруулж, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлчилгээг иргэдэд хүргэж, үйлчилгээний байгууллагуудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.
  - 4.6.2 Мэргэжлийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулж, худалдаа, үйлчилгээний байгууллагуудад хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна.
  - 4.6.3 Дүүргийн иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр тогтвортой хангах, бодлого баримталж ажиллана.



- 4.6.4 Бүх нийтийн хүнсний боловсролыг дээшлүүлэх, хоол хүнс, шим тэжээлийн чанар, аюулгүй байдлыг эрүүл амьдралын зан үйл хэвшилтэй нягт уялдуулах чиглэлээр үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

**ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО  
/АМЬДРАХАД ТААТАЙ СҮХБААТАР ДҮҮРЭГ/**

- 5.1 Иргэдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газрыг бий болгоно.
- 5.1.1 Хүүхэд, залуус, ахмад настнуудад зориулсан хүүхдийн тоглоом, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн төрөлжсөн талбайг шинээр байгуулах болон шинэчилж, тохижуулна.
- 5.1.2 Иргэдийн амарч зугаалах, чөлөөт цагаа өнгөрөөх бүхий ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн нэмж байгуулна.
- 5.2 Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.
- 5.2.1 Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийг сайжруулж, камержуулах хяналтын цогц шийдлийг нэмэгдүүлнэ.
- 5.2.2 Иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран Сэлбэ цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 5.2.3 Гэр хорооллын гудамж талбайд сайжруулсан шороон зам, орон сууцны хороолол доторх авто замыг засварлах, хатуу хучилттай болгож, тоосжилтыг бууруулна.
- 5.2.4 Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлын чанар, үр ашгийг нэмэгдүүлж, арчлалт, хамгаалалтыг иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 5.2.5 Байгаль орчныг хамгаалах, ногоон байгууламж шинээр бий болгосон иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг дэмжиж, тэдгээрийг арчлан хамгаалах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 5.2.6 Дүүргийн хэмжээнд хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор “ЖОРЛОНГОО ӨӨРЧИЛЬЕ” арга хэмжээг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.
- 5.2.7 Гэр хорооллын гудамж, замыг тохижуулах иргэдийн хүсэлтийн дагуу саналыг авч, иргэдийн оролцоотой “ЖИШИГ ГУДАМЖ- МАНАЙ ГУДАМЖ” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.2.8 Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг техник, тоног төхөөрөмжөөр хангаж, хүчин чадлыг нэмэгдүүлэн, далан суваг, шугам сүлжээний цэвэрлэгээ, үйлчилгээ, засварын ажлын чанарыг сайжруулж, иргэдийн цэвэр орчинд амьдрах орчныг сайжруулна.
- 5.2.9 Иргэдийн саналын дагуу нийтийн эзэмшлийн талбай дахь авто зогсоол, ногоон байгууламж, сул шороон хучилт, явган хүний зам, гүүр, шат, худаг усан сангийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 5.2.10 Угсармал орон сууцны байруудын дулааны алдагдлыг бууруулах зорилгоор дээврийн болон фасад засварлах, дулаалах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 5.2.11 Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, байгууламжийн цэвэрлэгээ, ариутгал, усалгаа, засвар үйлчилгээг тогтмол хийж, засвар үйлчилгээний чанарыг сайжруулж, гүйцэтгэлийг үнэлэн санхүүжилт олгоно.
- 5.3 Агаарын бохирдлыг бууруулж, хог хаягдлын менежментийг сайжруулна.
- 5.3.1 Агаарын бохирдлыг бууруулах талаар хувийн хэвшлийн байгууллагуудын шинэ санаачилга дэвшилтэт технологийг дэмжин ажиллана.

- 5.3.2 Суурьшлын бүсийн хөрсний доройтол, бохирдлыг бууруулах, хөрсний ус болон зам, талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээг хотын ерөнхий төлөвлөлттэй уялдуулан шинээр барих болон өргөтгөн шинэчилнэ.
- 5.3.3 Ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтоож, ундны усны эх үүсвэрийн гүний худаг, тоолуургүй айл өрх, аж ахуйн нэгжийг тоолууржуулах болон аж ахуйн нэгж, байгууллагуудыг хаягдал усаа цэвэршүүлэн дахин ашиглах, ашиглалтын хугацаа дууссан гадна болон дотор шугам сүлжээний засвар шинэчлэлтийг холбогдох газруудтай хамтран зохион байгуулж, шугам сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж, усны үргүй зардлыг бууруулна.
- 5.3.4 Хууль бус мод бэлтгэл, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, ан агнуур, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож буй иргэн, аж ахуйн нэгжид урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, тавих хяналтыг сайжруулна.
- 5.3.5 Орчны бохирдол, үнс, хог хаягдлыг бууруулах чиглэлээр хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах менежментийн цогц бодлого хэрэгжүүлнэ.
- 5.3.6 Дүүргийн нутаг дэвсгэрт Засгийн газрын 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулж, үерийн далан сувагт хаясан ил задгай хог хаягдлыг бууруулах хяналт шалгалт хийнэ.

#### ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО /ГАЗРЫН ХАРИЛЦАА, ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ/

- 6.1 Газар зохион байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.
  - 6.1.1 “Зуслангийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”-ний дагуу газар өмчлөх ажлыг хот төлөвлөлтийн бодлоготой уялдуулан холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
  - 6.1.2 Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тохижилт бүтээн байгуулалт хийх ажлын байршлуудыг тусгаж батлуулна.
  - 6.1.3 Гэр хорооллын мухар гудамж, зуслангийн орц, гарц, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам талбайн газрын зөрчлийг арилгаж, түргэн тусламж, гал унтраах аврах ажиллагааг саадгүй нэвтрэх боломжийг бүрдүүлнэ.
  - 6.1.4 Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд нийтийн болон, амины орон сууцыг шинээр бий болгох хөтөлбөрийг дэмжин, холбогдох байгууллага аж ахуй нэгж иргэдтэй хамтран хэрэгжүүлнэ.
  - 6.1.5 Улс, нийслэл болон гадны төсөл, хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа инженерийн дэд бүтцэд гэр хорооллын айл өрхийг төвийн болон хэсэгчилсэн бие даасан байдлаар холбох ажилд дэмжлэг үзүүлэн ажиллана.
  - 6.1.6 Дүүргийн хэмжээнд геодезийн устсан болон шинээр суулгасан цэг, тэмдэгтийн мэдээллийг тоолох ажлыг зохион байгуулна.
  - 6.1.7 Дүүргийн нутаг дэвсгэр дэх голын болон үерийн хамгаалалтын барилга байгууламжийн хамгаалалтын бүсийг нарийвчлан тогтоож, тус бүсэд байгаа айл өрх, аж ахуйн нэгж байгууллагыг нүүлгэн шилжүүлэх, үерийн хамгаалалтын далан, сувгийг шинэчлэх болон шинээр барьж байгуулна.